



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/352

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэхь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авто замын сангийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Сумын төвийн зам засвар, арчлалт /Хутаг-Өндөр сум/” ажлын гүйцэтгэгчээр Орхон аймгийн “Энх-Алтаргана” ХХК-ийг шалгаруулж 49,794,919 (Дөчин есөн сая долоон зуун ерэн дөрвөн мянга есөн зуун арван есөн) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Энх-Алтаргана” ХХК-ийн захирал (А.Энхжаргал)-д даалгасугай.

3. Дээрх ажлын санхүүжилтийг хууль, журам, гэрээний дагуу тооцон олгохыг Аймгийн төсвийн нягтлан бодогч (О.Сайнзаяа)-д зөвшөөрсүгэй.

4. Хөрөнгийг данс бүртгэлд тусгаж ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Хутаг-Өндөр сумын Засаг дарга (П.Лхагва-Очир)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 15 ны/ний өдрийн А/352 дугаар
захирамжийн хавсралт

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	О.Сайнзаяа
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь.	О.Сайнзаяа
3	Захиалагчийн хяналтын зардал	543,946	Ү.Бямбасүрэн
4	Магадлашгүй ажил	876,352	Ү.Бямбасүрэн
5	Ажил гүйцэтгэх хугацаа	45 хоног	Ү.Бямбасүрэн
6	Нормчлолын сан	175,270	Ү.Бямбасүрэн
7	Зураг төсөл	0	Ү.Бямбасүрэн